



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/25

Жаргалтхаан сум

Эрчим хүчний шугам сүлжээнд
хамгаалалтын зурвас тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.1 2.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020 оны А/459 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрчим хүчний шугам сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг саадгүй явуулах, хүн ам осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор эрчим хүчний шугам сүлжээнд хамгаалалтын зурвасыг шугам сүлжээний ангилал тус бүрээр тогтоож хавсралтаар баталсугай.

2. Хамгаалалтын зурвас дотор барилга байгууламж, орон сууц, гэр, хашаа барих, шугам сүлжээ эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.


3. Захирамжийн биелэлтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг Багануур цахилгаан түгээх сүлжээ салбарын шуурхай үйлчилгээ, засварын техникч (Э.Ганбаяр), шуурхай үйлчилгээ, засварын монтёр (Ш.Галтхүү) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ

Сумын Засаг даргын 2026 оны
03 сарын 09 өдрийн 1/33 дугаар
захирамжийн хавсралт



Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас

№	Шугам сүлжээний ангилал	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах байгууламж	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш	
1	Цахилгаан дамжуулах шугам: а/ 1кВ хүртэл	-	1 м	-	-	-
	б/1-20 хүртэл кВ	10 м	2 м	10 м	-	-
	в/35 кВ	15 м	4 м	15 м	-	-
	г/110 кВ	20 м	5 м	20 м	-	-
	д/220 кВ	25 м	6 м	25 м	-	-
	е/330-500 кВ	30 м	10 м	30 м	-	-
2	Кабель шугам	-	-	-	-	1 м
3	Дулааны шугам: а/500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м
	б/500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м
4	Үндсэн сан			30 м		